ЖИЛИЙН ТАЙЛАН

Монгол Улс 2024

ADRA 30 YEARS OF JUSTICE, COMPASSION, LOVE

30 жилийн ойн хэвлэл

ADRA

Editorial

Эмхэтгэл/Дизайн
Г. Баясгалан

Хянасан
Винделл М. Маранан
Б. Ундрах
Ракуэл Маранан

Боловсруулсан
Г. Баясгалан
Б. Асемгүл
С. Алтанцэцэг
Д. Ганчимэг
Б. Оргилзул

ХОЛБОО БАРИХ

НИЙТЛЭГЧ
АДРА Монгол

Адвентист Хөгжил
Туслалцааны Агентлаг

Палаззо Цамхаг #8-401
Токиогийн гудамж, 1-р Хороо
Баянзүрх дүүрэг
Улаанбаатар, Монгол Улс
15160

+976-11-450738
www.adra.org.mn

АГУУЛГА

3 ӨМНӨХ ҮГ

4 МЭНДЧИЛГЭЭНҮҮД

7 АДРА ОУБ-ЫН ТАНИЛЦУУЛГА

8 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


11 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРУУД

12 БИДНИЙ 30 ЖИЛИЙН ОЙ

20 ЭРС ТЭС УУР АМЬСГАЛД НИЙЦСЭН ГАЗАР ТАРИАЛАН ТӨСӨЛ

24 БЭЛЧЭЭРИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ

28 ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ - 2 ТӨСӨЛ

33 ЗУДЫН ЯАРАЛТАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨЛ

38 НАРИЙН БОЛОН НАРИЙВТАР НООСТ ХОНИНЫ ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

43 ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ

48 ДЭМ ДЭМЭНДЭЭ ТӨСӨЛ


50 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

51 САНХҮҮЖҮҮЛЭГЧ БОЛОН ТҮНШЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

ӨМНӨХ ҮГ

Тус байгууллага нь хүртээмжтэй хөгжил, үр нөлөөтэй тогтвортой өөрчлөлтийн төлөө тууштай зүтгэсэн 30 жилийн ой дээрээ Та бүхэнд 2024 оны жилийн тайлангаа танилцуулж байна. Сүүлийн гурван арван жилийн туршид бид дэмжлэг нэн шаардлагатай нийгмийн бүлэг, орон нутгийн иргэд, төрийн, төрийн бус, эрдэм шинжилгээний зэрэг бусад байгууллагуудтай үр дүнтэй нягт хамтран ажиллаж, онцгой байдлын үеийн нэн яаралтай тусламжийн арга хэмжээ үзүүлэхээс эхлээд, хөдөө аж ахуйн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн өргөн хүрээний төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр иржээ.

Бид санхүүжүүлэгч, дэмжигч байгууллагууд, нийт түншлэгч талуудтай тулгарч буй сорилтуудыг үр дүнтэй даван туулах шийдлийг хамтран эрэлхийлж, шинэлэг арга барилыг нэвтрүүлэн үр дүнтэй хамтран ажиллахыг үргэлж зорьдог. Иймд энэхүү тайланд онцолсон ололт амжилтууд нь төслүүдийн ололт амжилтыг илэрхийлэхээс гадна бидний эрхэм зорилгын үндэс болсон үр дүнтэй түншлэлийн үр дүн юм. Хамтын ажиллагааны үр дүнд бид хамтдаа сорилтуудыг даван туулж, шинэ боломжуудыг бий болгож, бодитой, тогтвортой шийдлүүдийг хэрэгжүүлсээр иржээ. Ийнхүү бидний ажил олон гэр бүл, хүмүүсийн амьдралын чанар, итгэл найдвар, чадавхыг дэмжих, нэмэгдүүлэх замаар эерэг өөрчлөлтийг хамтдаа бүтээхийг зорьдог.

Ингээд бидний үйл ажиллагааг дэмжин ажилладаг санхүүжүүлэгч, хандивлагч, хамтрагч байгууллагууд, дэмжигчид нийт түншлэгч талууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний тусламж, дэмжлэг, хамтын ажиллагаа бодит өөрчлөлтийн төлөө тууштай ажиллах боломжийг олгодог ба цаашид ч илүү үр нөлөөнд хүрэхийн тулд сэтгэл, зүтгэл нэг хамтран урагшилна гэдэгт итгэлтэй байна.

АДРА ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

"Итгэл найдвар" нь АДРА Монгол байгуулагдсаны 30 жилийн ойгоор хамтдаа тэмдэглэхэд сайхан зүйл билээ!

АДРА нь 1994 онд МУ-ын Ерөнхий Сайдын урилгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн анхны олон улсын төрийн бус байгууллага юм. Коммунист тогтолцоо нуран унасны дараа Монгол улсад төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага их байсан хэдий ч сайн сайхны төлөөх "Итгэл найдвар" ч мөн тэр хэрээр их байсан.

АДРА-гийн тус улсад хэрэгжүүлсэн хамгийн анхны хөтөлбөрүүд нь өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийг хооллох, эрүүл мэнд, амьжиргааг сайжруулах, гамшгийн үеийн хариу арга хэмжээ үзүүлэх, хүртээмжтэй боловсрол эзэмших боломжийг олгох зорилготой байв. Байгуулагдсан зорилго, сайн сайхны төлөөх итгэл найдвар нь 30 жилийн хугацаанд 200 орчим төслүүдийг хэрэгжүүлсэн амжилтад хөтөлж чаджээ!

Өнөөдөр ч АДРА-гийн үйл ажиллагаа нь сайн сайхан нийгмийн төлөө чиглэсэн хэвээр байна. Даван туулах дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, гамшгийн үеийн хариу арга хэмжээ, эерэг дадал зуршлыг төлөвшүүлэх, бүтээмжтэй, үр ашигтай тариаланчид, малчин өрхүүдийг дэмжих, чадавхжуулахад чиглэсэн төслүүдээрээ дамжуулан хүмүүсийг бодитой эерэг өөрчлөлтийг өрнүүлэхэд "Итгэл найдвар" түгээсээр.

Энэхүү ойн баяраа тэмдэглэхийн сацуу АДРА-гийн ололт амжилт зөвхөн биднийх биш гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Бурханы ивээлээр биднийг дэмждэг санхүүжүүлэгч талууд, бидний сайн сайхны төлөө залбирдаг найз нөхөд, гэр бүл, бидэнтэй нөхөрсөг, нээлттэй хамтран ажилладаг нийт түншлэгч талуудын сэтгэл, хүчин чармайлтын үр дүнд энэхүү ойн арга хэмжээг өнөөдөр тэмдэглэх боломж бүрдсэн.

Би АДРА Монголын хийж буй ажлаар үнэхээр бахархаж байна. Сүүлийн гучин жилийн турш тэдний тээсэн тэр л "Итгэл найдвар"-ыг би өнөөдөр ч тэдний үйл ажиллагаанаас тодоор харж байна. Бурханы ивээлээр энэ л "Итгэл найдвар" тэднийг дараагийн 30 жил, түүнээс ч цааш үргэлжлүүлэн хөтөлнө гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

Майкл Крюгер
Ерөнхийлөгч
АДРА Интернэйшнэл

АДРА АЗИЙН БҮСИЙН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт АДРА Монгол байгууллагын хамт олонд,

АДРА Азийн бүсийн төлөөлөгчийн газрын нэрийн өмнөөс Та бүхэнд 30 жилийн ойн баярын халуун мэндийг хүргэе. Энэхүү чухал үйл явдал нь орон даяар олон хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө Та бүхний хоёргүй сэтгэл, уйгагүй хичээл зүтгэл гарган ажилласныг харуулж байна гэж бодож байна. Өнгөрсөн гучин жилийн аялал нь урт хугацаанд тууштай үргэлжилсэн ба энэхүү чухал арга хэмжээг Та бүхэнтэй хамт тэмдэглэж байгаадаа баяртай байна.

АДРА Монгол нь дэлхий даяарх АДРА-гийн 120 гаруй төлөөлөгчийн газрын нэг билээ. Адвентист Хөгжил, Туслалцааны Агентлаг (АДРА) нь Долоо дахь өдрийн Адвентист сүмийн бие даасан хүмүүнлэгийн мэргэжлийн байгууллага юм. Бид үндэс угсаа, улс төрийн үзэл бодол, хүйс, шашин шүтлэгээс үл хамааран хувь хүн, олон нийтэд чиглэсэн хүмүүнлэгийн болон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлдэг.

АДРА Монгол 1994 онд үүдээ нээснээс хойш итгэл найдварын очийг бадраахыг хичээн, эерэг өөрчлөлтийг дэмжигч, эрчимжүүлэгч байхыг тасралтгүй зорьж ирсэн. Та бүхний хэрэгжүүлж буй “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах”, “Органик хөдөө аж ахуйн түншлэл” зэрэг шинэлэг төслүүд нь иргэдийн амьжиргааг дэмжихээс гадна тогтвортой хөгжил, даван туулах, дасан зохицох чадавхыг орон нутагт бэхжүүлэхийг дэмжиж байна. Эрүүл мэнд/хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал/хөдөө аж ахуй, амьжиргаа, онцгой байдал/гамшгийн үеийн хариу арга хэмжээний хүрээн дэх ажлууд нь “Шударга ёс, энэрэл, хайр” зарчмын дагуу хүмүүст үйлчилснээр эерэг үр нөлөөг авчирсан гэдэгт итгэж байна.

Тогтвортой хөдөө аж ахуй, эрүүл мэнд, шим тэжээлийг сайжруулах, дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн хүн амд гамшгийн үеийн тусламжийн хариу арга үзүүлэх зэрэг чиглэлээр хийсэн ажлуудыг энэ хүрээнд дурдмаар байна. Түүнчлэн “Бэлчээрийн цогц менежмент”, “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх” зэрэг төслүүд нь инновацыг нэвтрүүлэх, шинэ санаачилгыг хэрэгжүүлэх ажлын жишээ гэж харж байна. Эдгээр хүчин чармайлт нь зөвхөн АДРА Монгол төдийгүй АДРА-гийн нийт сүлжээ байгууллагуудын хувьд бахархах зүйл билээ.

Та бүхэн хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад нь үйлчлэх цаашдын аянд нь бид Танай баг хамт олон, Та бүхний түншлэгч нийт талуудад Бурханы ивээлийг хүсэн ерөөе. Эхний 30 жилийн турш эерэг өөрчлөлтийн төлөө зорьж, баримталж ирсэн тэр л хичээл зүтгэл, хүсэл тэмүүллээр үргэлжлүүлэн ажиллахыг хүсье. АДРА Монгол байгууллагын үйл ажиллагаа өргөжин тэлж, амжилт бүтээлээр дүүрэн байхыг бид ирэх олон жилүүдэд ч гэрчилнэ гэдэгт итгэж байна.

Хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Фрэнк Рейманн
Бүсийн дарга
АДРА Азийн бүсийн төлөөлөгчийн газар

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт найз нөхөд, хамтран зүтгэгсэд ээ,

АДРА Монголын 30 жилийн ойн баярыг тэмдэглэж буй энэ үед, 1994 онд байгуулагдсанаас хойш нийгмийн эмзэг бүлгийнхэн болон тусламж нэн шаардлагатай хүмүүст хүрч ажиллахад тулгарсан олон бэрхшээлийг үл хамааран, энэхүү байгууллагын амжилтын нэгээхэн хэсэг болж буйдаа туйлын баяртай байна.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Долоо дахь өдрийн Адвентист сүмийн хүмүүнлэг, хөгжлийн мэргэшсэн байгууллагын хувьд бурханы ивээл дор хүмүүнлэгийн салбарынхан бид сэтгэл нэг зүтгэхээс гадна, бидний нийт хамтрагч, дэмжигч, санхүүжүүлэгч, болон бусад олон хүмүүсийн тууштай хүчин чармайлтын үр дүнд олон хүний амьдралыг чанарыг дээшлүүлэн, эерэг өөрчлөлтийг хамтдаа бүтээсээр иржээ.

Бид үргэлж хүмүүстэй ойр ажиллаж, тэдний хүсэл, хэрэгцээг сонсож, ойлгон, хамтдаа шийдэл олж, ирээдүйгээ илүү гэгээтэй бүтээхэд нь дэмжин ажиллахыг зорьдог. Гамшгийн үед хариу арга хэмжээ үзүүлэх, тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөөх бүхий л үйл ажиллагаандаа тус байгууллага нь хүн бүрд байдаг эрхэм чанарыг хүлээн зөвшөөрч, хүн бүрийн нэр төртэй, боломж дүүрэн амьдрах эрхийг хангахын төлөө чин сэтгэлээсээ, тууштайгаар дэмжин ажиллахыг эрмэлздэг. Энэ нь хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад нь туслах бидний туйлын зорилгын тусгал билээ.

Энэхүү гайхалтай аяллын нэг хэсэг болж байгаадаа би туйлын их баяртай байгаа бөгөөд дараагийн шинэ бүлгийг эхлүүлэн, үргэлжлүүлэхэд ч Та бүхний хамт цаашид зорилгын төлөө зүтгэнэ. Библид Мика 6:8-д “Хүн ээ, юу нь сайн болохыг Тэр чамд айлдсан. Шударгыг үйлд, энэрлийг хайрла, өөрийн Бурхантай хамт даруухнаар алх гэхээс өөр юуг Тэр чамаас шаарддаг вэ?”. Энэ нь АДРА-гийн хүмүүнлэгийн сүлжээний уриа болох “Шударга ёс. Энэрэл. Хайр.” гэсэн зарчмуудын үндэс суурь бөгөөд бид хамгийн сайнаараа эдгээр зарчмыг мөрдөн ажиллахыг хичээдэг.

Бид “Итгэл найдвар”-ийг 30 жилийн ой дээрээ тэмдэглэж буй энэ үед Та бүхний тууштай дэмжлэг, сэтгэл зүтгэлд дахин гүн талархал илэрхийлье!

Хүндэтгэсэн,

ВИНДЕЛЛ М.МАРАНАН
Суурин төлөөлөгч

АДРА ОУБ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг (АДРА) нь 1956 онд Долоо дахь өдрийн Адвентист сүмийн үүсгэн байгуулсан, бие даасан хүмүүнлэгийн байгууллага юм. АДРА нь хөгжиж буй орнууд дахь нийгмийн шударга бус байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх, тусламж хэрэгтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө ажилладаг. АДРА нь дэлхийн 130 гаруй улсад төлөөлөгчийн газартай бөгөөд тэдгээрийн нэг нь АДРА Монгол билээ.

АДРА Монгол ОУБ нь Монгол улсад 1994 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэн, өнгөрсөн 30 жилийн турш иргэд, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, Монголчуудын амьдралын чанарыг сайжруулахын төлөө хүнсний аюулгүй байдал, иргэдийн амьжиргаа/эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, гамшгийн эрсдэлийг бууруулах таван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсээр ирсэн.

Өнөөдрийн байдлаар, АДРА дээрх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 194 төсөл хэрэгжүүлээд байна. Нийт зарцуулсан санхүүжилтийн хэмжээ ойролцоогоор 34,436,588 сая ам.долларт хүрсэн бөгөөд нэг жилд дунджаар 1,187,468 сая ам.доллар зарцуулжээ.

Алсын хараа

АДРА Монгол ОУБ нь мэргэшсэн, шинийг эрэлхийлэгч, тасралтгүй суралцагч, үр дүнтэй үйл ажиллагаа бүхий нэгдсэн, шударга, ил тод байдлыг хангасан олон улсын сүлжээ байгууллагад харьяалагддаг. АДРА нь орон зай, хил хязгаарыг үл харгалзан нийгмийн эрсдэлт болон дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн хүмүүсийг чадавхжуулан тэдний дуу хоолойг өргөн, тэдний амьдралд хэмжигдэхүйц, бодит, тогтвортой өөрчлөлтүүдийг авчрахын төлөө ажилладаг.

Мөн чанар

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг нь Бурханы хайр энэрлийг үзүүлдэг Долоо дахь өдрийн Адвентист сүмийн байгуулсан, даян дэлхийн хүмүүнлэгийн байгууллага юм.

Эрхэм зорилго

Хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад туслах.

Боловсрол	Гамшгийн хариу арга хэмжээ	Амьжиргаа/ эдийн засаг	Эрүүл мэнд	Хүнсний аюулгүй байдал
58 төсөл	25 төсөл	32 төсөл	37 төсөл	42 төсөл

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2024 он АДРА Монгол ОУБ-ын хувьд нэн чухал тэмдэглэлт жил болж өнгөрлөө. Бид Монгол улсад 30 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрахын төлөө тууштай зүтгэсэн түүхэн ойн арга хэмжээг түншлэгч талуудын хамт зохион байгуулав. 2024 онд бид хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, гамшгийн үеийн хариу арга хэмжээ, боловсролын салбарт голлон анхаарч, тогтвортой өөрчлөлтийг бий болгох эрхэм зорилгынхоо хүрээнд үргэлжлүүлэн ажиллалаа.

Бид ялангуяа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, даван туулах чадавхтай хөдөө аж ахуйн чиглэлээрх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, Баян-Өлгий аймгийн 3 сумдад “Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд бид жижиг хэмжээний наран хүлэмжийг нэвтрүүлснээр тариалалтын хугацаа 3 сар байсныг 8 сар болгон уртасгаж, эрт хяруу унах, ургац хөлдөх эрсдэлээс сэргийлсэн нь тариалалтын менежмент болон хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэв. Ингэснээр иргэдийн амьжиргаа, эрүүл шим тэжээлтэй хүнсний хангамжийг нэмэгдүүлэхийг зорьсон.

Шинэ төслийг хэрэгжүүлж эхлэхийн зэрэгцээ Завхан аймагт “Бэлчээрийн цогц менежмент” төслийн хаалтын үйл ажиллагааг “Ололт, амжилт, сургамж” нэртэйгээр талуудын хамт амжилттай зохион байгууллаа. Энэхүү төсөл нь бэлчээрийн цогц менежментийн аргыг Монгол Улсад, тус аймагт анх удаа нэвтрүүлж, туршсан төсөл байсан бөгөөд малчин өрхүүд уг аргыг амжилттай нэвтрүүлснээр нийтийн бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга барилд суралцсан. Төслийн үр дүнд бэлчээр ашиглалтын бүтээмж төдийгүй бэлчээрийн чанар туршилтын талбайд тогтвортой нөхөн сэргэсэн зэрэг эерэг үзүүлэлтүүд нь төслийн эерэг үр нөлөөг харуулав. Малын чанарыг сайжруулах замаар малчин иргэдийн амьжиргааг дэмжих зорилготой “Нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах төсөл”-ийн 2-р үе шат хэрэгжиж эхэлсэн бөгөөд, төслийн хүрээнд малчид болон малын үржлийн мэргэжилтнүүдэд түлхүү анхаарч ажиллав. Энэ хүрээнд 2 аймгийн 4 суманд 680 толгой хонинд зохиомол хээлтүүлэг дурангийн аргаар хийв. Мөн малчид, мал аж ахуйн болон үржлийн мэргэжилтнүүдэд дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх практик сургалт явуулсан нь тэдний чадавхыг бэхжүүлэх, шинэлэг арга барилыг практик дээр сурах, урт хугацаанд үр өгөөжтэй, нэн шаардлагатай ур чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэсэн чухал үйл ажиллагаа болсон.

Манай “Органик хөдөө аж ахуйн түншлэл-2” төсөл нь Сэлэнгэ болон Дархан-Уул аймгуудад органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тэлж, органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын үр ашигтай сүлжээг хөгжүүлэх зорилготойгоор 2 дахь жилдээ хэрэгжлээ. Төслийн хүрээнд бид органик газар тариалангийн сургагч багш бэлтгэх, органик үйлдвэрлэлийн арга техник, стандарт, хоршооны засаглал, нийлүүлэлтийн сүлжээ, маркетингийн арга зүй, хамтын баталгаажуулалт, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хоршоодын эрэлт хэрэгцээнд суурилсан бусад мэргэжлийн сургалтууд зэрэг чухал ур чадварыг эзэмшүүлэх цогц сургалтуудыг нийт 716 хоршооны гишүүдэд амжилттай зохион байгуулав.

мөн хоршоодын гишүүдийн нийт 376 бүтээгдэхүүнийг “100 хувь органик”-аар баталгаажуулах, албан ёсны тэмдэг тэмдэглэгээтэйгээр зах зээлд нийлүүлэх эрх авах үйл ажиллагааг дэмжиж ажиллав.

Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн мэдлэг олгох, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх замаар халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх зорилготой төслийн хүрээнд “Эрүүл амьдралын 12 зарчим”-аас бид дасгал хөдөлгөөн, тэсвэр тэвчээр, өөдрөг сэтгэлгээ, хоол тэжээл гэсэн 4 зарчимд төвлөрч ажиллалаа. Хамтрагч сургуулиудын өсвөр үеийнхэнд тулгарч буй асуудлуудыг ойлгох, илрүүлэх зорилгоор мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгаа, саад бэрхшээлийн шинжилгээ, оролцооны аргад суурилсан хүн төвтэй арга барилын дагуу уулзалт, семинарыг хүүхдүүдийн дунд зохион байгуулав. Эдгээр судалгаа, болон өсвөр үеийнхний санал санаачилгад үндэслэн хамгийн үр дүнтэй арга замуудыг тодорхойлж, үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг хамтрагч талуудын хамт хөгжүүлж, туршиж, хэрэгжүүлж эхлээд байна.

Эцэст нь бид гашгийн хариу арга хэмжээг дэмжих зорилгоор зудын гамшигт өртсөн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын тусламж нэн шаардлагатай 167 малчин өрхөд бэлэн мөнгөний, мөн сумын засаг захиргаанд сэг зэмийг шуурхай цэвэрлэхэд түлшний дэмжлэг үзүүлэв. Мөн манай байгууллагын хамт олон, хувиараа хандивлагчдын санхүүжилтээр хэрэгждэг уламжлалт “Дэм дэмэндээ” төслийг үргэлжлүүлж, Улаанбаатар хотын дэмжлэг нэн шаардлагатай 100 өрхөд хүнсний тусламжийн багц, 50 хүүхдэд өвлийн дулаан гутал олгов.

2024

оны онцлох ажлууд



816

өсвөр үеийнхэн, багш нар болон бусад оролцогч талууд CELEBRATIONS эрүүл амьдралын хэв маяг, хандлагад суралцаж байна

895

500 тариаланчид 895 тонн органик хүнсний ногоо болон зөгийн бал хураан авсан

1,035

тариаланчид ногооны ургацаа сайжруулан нарны хүлэмжийн үр ашгийг хүртэж байна

4,475

зорилтот бүлгийн тусламж нэн шаардлагатай иргэдэд зудын гамшгийн үеэр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн

630

хонинд зохиомол хээлтүүлэг хийснээр 474 нарийн ноост төл төллөлөө

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРУУД





Бидний түүхийн эхлэл

ADRA Mongolia 30

ИТГЭЛ НАЙДВАР БА ХАТУУЖЛЫН АЯЛАЛ

1994 оны 5-р сард АДРА Монгол байгууллагын анхны Суурин төлөөлөгч, үүсгэн байгуулагч Скотт Кристиансен ихээхэн хүлээлт, тодорхойгүй байдлын дунд Хонконгт газардлаа. Тэрээр АДРА-гийн Ази дахь бүсийн Зохицуулагч Мэйтланд Дипинтотой уулзахаар ирсэн байв. Скотт Монгол Улсад АДРА-гийн үйл ажиллагааг социалист дэглэмээс шилжсэний дараах тэр л үед эхлүүлэх хариуцлагатай үүрэг хүлээсэн бөгөөд энэ нь түүний хувьд маш том сорилт байв. Учир нь тэрээр Мексик рүү хийсэн хэдхэн аяллаас өөрөөр олон улсад ажилласан туршлагагүй байлаа.

Тэдний Монгол руу хийх аялал хуучин Орос Улсын Туполев онгоцоор эхэлсэн бөгөөд онгоцны элэгдсэн урд дугуй Монголын тэр үеийн хүнд нөхцөл байдлыг илтгэх шиг. Тухайн үед дугуй хагарч, онгоц хүчтэй доргион дунд газардахад энэ улс ямар хүнд хэцүү цаг үеийг туулж байгааг улам ч гэрчлэх шиг.

Улаанбаатар хотод хүрэлцэн ирснийхээ дараа Скотт, Мэйтланд нар Гадаад хэргийн яамтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах талаар болгоомжтой, няхуур яриа хэлэлцээр хийж эхэлсэн. АДРА нь Монгол Улсад албан ёсны үйл ажиллагаагаа явуулахаар ирсэн анхны ТББ байсантай холбоотой тус яамны зүгээс ч бас болгоомжлол, эргэлзээ байсан нь тухайн үеийн ДНБ-ний 80 хувьтай тэнцэх Зөвлөлтийн дэмжлэгээс хамааралтай байсантай холбоотой болов уу. Гэвч энэхүү санхүүжилт гэнэт тасарч, улс орон даяар эдийн засаг гүн хямралд орж, эдийн засгийг сэргээх хүндхэн үед байлаа.

Эдгээр няхуур яриа хэлэлцээр үргэлжилж байх үед Скотт Монголд Адвентист сүмийг анхлан байгуулахаар ажиллаж байсан Брэд, Кэти Жолли нартай танилцсан. Мөн Мэйтланд чухал шийдвэр гаргаж, Скоттын орчуулагч, туслахаар Мягмарын Мөнхжаргалыг ажилд авсан нь цаашдын үйл ажиллагаанд тун ач холбогдолтой шийдвэр байлаа.

1994 оны 8-р сард Скотт гэр бүлтэйгээ цуг Монголд дахин ирсэн. Тухайн үед Гадаад хэргийн яамнаас нэг даруухан өрөө түрээсэлж АДРА-гийн анхны оффисыг байгуулж байв. Скоттын гол зорилго бол Монголын хамгийн эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагыг ойлгож, хангах явдал байлаа. Тэрээр гудамжны траншейнд амьдардаг олон хүүхдийг харсан хэдий ч гудамжны хүүхдүүдийн тоог улам нэмэгдүүлнэ гэсэн болгоомжлолоос үүдэн Гадаад хэргийн яам хүүхдүүдэд шууд тусламж үзүүлэхийг хориглов.

Скотт, Мөнхжаргал нар нийслэл болон орон нутгаар явж, тусламжийн хөтөлбөр боловсруулсан хэдий ч хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, мэргэжлийн мэдлэг дутмаг байв. Нөгөөтээгүүр, цаг хугацаа явахын хэрээр Гадаад хэргийн яам, тухайлбал АДРА-гаас машин, компьютер зэрэг материаллаг хангамжийн хүлээлттэй байсан ч АДРА тэдгээрийг тэр даруй хангах боломжгүй байсан юм. Тухайн үед олон улсын дуудлага маш өндөр төлбөртэй, интернэт огт байхгүй байсан тул АДРА-гийн төв байгууллагатай харилцахад зөвхөн факс ашиглах нь цаг хугацаа шаардсан хүндрэлтэй зүйл байсан.

Өвөл ойртож, нөхцөл байдал улам хүндэрч байхад Скоттын бухимдал дээд цэгтээ хүрэв. Гэвч 12-р сард АНУ-аас ирсэн ачаа бага ч болов найдвар төрүүлсэн. Энэхүү чингэлэг нь хувийн эд зүйлсээс гадна хүүхдүүдэд зориулсан дулаан өвлийн гутал, хувцас, мөн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн агуулсан байв.

Тэдгээр зүйлсийг гудамжинд амьдардаг хүүхдүүдэд шууд тараах боломжгүй байсан тул Жолли нарын залуу туслах Жулианыг орон нутгийн сайн дурынхантай хамтран түгээх ажлыг зохион байгуулахыг хүсжээ.

Харамсалтай нь бүх зүйл санаснаар болсонгүй. Жулиан гэгч залуугийн жинхэнэ нэрийг мэдэхгүй байсан Скотт гэнэт түүнийг баривчлагдсан тухай мэдээ сонсов. Монголын хэвлэл мэдээллээр Адвентист сүм болон АДРА-г ‘гадаадаас гэмт хэрэгтнүүдийг оруулж ирж байна’ гэх шуугиан дэгдэв. Мөнхжаргал тухайн үед айн болгоомжилж байсан ч Скотт түүнийг цааш ажиллахыг яттасан юм.

Мөнхжаргал засгийн газартай харилцаагаа сэргээх, бэхжүүлэх ажилд уйгагүй зүтгэж, олон гайхамшигтай ажлууд, үр дүнгийн гэрч болсон юм. Тодорхой шашин шүтлэггүй байсан тэрээр АНУ-д Адвентист семинарыг төгссөн анхны Монгол хүн болсон нь, нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөж байсныг харуулна.

Эдгээр сүүдэртэй зүйлсийг үл харгалзан, Жулианы дараагийн үеийн залуучууд хатуужин шантралгүй үлдэж, зарим нь Монголын Адвентист сүмийн ирээдүйн удирдагчид болж төлөвшсөн байна. Жулиан баривчлагдсанаас хоёр сарын дараа Цагаан сарын баярын үеэр АДРА ахмадын асрамжийн газарт тусламжийн бараа тараасан бөгөөд энэхүү үйл явдлыг үндэсний телевизээр шууд дамжуулсан юм. Монгол Улсын Ерөнхийлөгч үндэсний илтгэлдээ АДРА болон бусад олон улсын түншүүдэд талархал илэрхийлсэн нь олон нийтийн сөрөг хандлагыг эергээр өөрчилсөн түүхэн мөч байв.

АДРА Монголын аялал эхнээсээ л бэрхшээлээр дүүрэн байсан нь цаашдын тууштай байдал, хатуужлыг төлөвшүүлэхээр ивээгдсэн гэлтэй. Тус байгууллага нь дотоод болон гадаад олон сорилтыг даван туулж, Монголын ард түмэнд үйлчлэх, амьдралыг нь сайжруулах эрхэм зорилгодоо үнэнч үлдсэн юм. (Түүхийг өгүүлсэн: ***Скотт Кристиансен***)

АДРА Монгол байгуулагдсаны 30 жилийн ойн баяр

АДРА Монгол олон улсын байгууллага үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн баяраа 2024 оны 7-р сарын 26, 27-ны өдрүүдэд “ИТГЭЛ НАЙДВАРЫН 30 ЖИЛ” гэсэн уриа дор Блү Скай зочид буудлын Эмералд танхим болон Улаанбаатар дахь Адвентист Төв сүмд тус тус амжилттай зохион байгууллаа.

АДРА нь Монгол Улсад 1994 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэн, өнгөрсөн 30 жилийн турш иргэд, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, Монголчуудын амьдралын чанарыг сайжруулахын төлөө 1994 оноос хойш одоог хүртэл хүнсний аюулгүй байдал, иргэдийн амьжиргаа/эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээнд төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсээр ирсэн.

Тус байгууллага нь коммунист тогтолцоо нуран унасны дараа буюу 1994 онд МУ-ын Ерөнхий сайдын урилгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн Монгол дахь анхны олон улсын төрийн бус байгууллага бөгөөд Азийн бүсэд хүмүүнлэг, хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг 17 суурин төлөөлөгчийн газрын нэг юм.

Ойн баярын үеэр Монголын Энх тайван, Найрамдлын Байгууллагын Ерөнхийлөгч Д.Загджав АДРА Монгол дахь суурин төлөөлөгч Винделл М. Марананийг Энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны дээд шагнал “Энхийн Алтан-Од” одонгоор шагналаа.

Мөн АДРА Монгол ОУБ-д 26 жил тасралтгүй ажилласан ахмад жолооч Жамбажавын Энхтөр Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдсан билээ.

Эхний өдрийн арга хэмжээнд АДРА Интернэйшнэлийн Ерөнхийлөгч Майкл Крюгер; АДРА Азийн бүсийн дарга Фрэнк Рейманн; НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагч Тапан Мишра; Монголын Адвентист Чуулганы ерөнхийлөгч Пастор Яанг ЕйСик; АДРА Германы гүйцэтгэх захирал Кристиан Молке; АДРА Монголын суурин төлөөлөгч асан Ллевелин Жуби, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн зэрэг ОУ-ын, төрийн мөн АДРА-гийн сүлжээ байгууллагын өндөр албаны төлөөлөгчид оролцов.

Манай хүндэт зочин илтгэгч болох АДРА Интернэйшнэлийн Ерөнхийлөгч Майкл Крюгер АДРА Монголын хамт олон болон баярын үйл ажиллагаанд оролцогчдод чин сэтгэлийн мэндчилгээг үндсэн ойн арга хэмжээгээр мөн, Улаанбаатар дахь Адвентист төв сүмд болсон талархлын цайллагын шаббат өдөр дэвшүүлэн, хүмүүнлэгийн сүлжээ байгууллагын чин зорилго, үйл ажиллагааны талаар номлолоо.

YEARS OF
JUSTICE, COMPASSION, LOVE
COME
a's 30th Anniversary
Speaker
L KRUGER
ADRA Mongolia
30
YEARS OF
JUSTICE, COMPASSION, LOVE

ADRA
Mongolia

2024 оны
Онцлох ажлууд

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

ЭРС ТЭС УУР АМЬСГАЛД НИЙЦСЭН ГАЗАР ТАРИАЛАН ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
АДРА Япон болон
АДРА ХонгКонг

Нийт төсөв (ам.доллар)
$340,000.00

Төсөл хэрэгжих хугацаа
2024 оны 4 сарын 1-нээс
2027 оны 3 сарын 31

Зорилтот бүс
Баян-Өлгий аймгийн Бугат,
Сагсай, Өлгий сумууд

Үр шим хүртэгсэд
225 өрхийн тариаланчид
(48,000 шууд бус)

Төслийн танилцуулга

Уг туршилтын төсөл нь тус аймгийн хүйтэн сэрүүн бүсэд тариалалтын хугацааг уртасгах боломжийг бүрдүүлэх наран хүлэмжийн тариалалтын шинэлэг арга барилыг нэвтрүүлж, хүнсний ногооны тариалалтын хугацаа, бүтээмжийг нэмэгдүүлэхийг зорихын зэрэгцээ хүнсний ногоо тариаланчдын үр ашигтай маркетинг, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх зорилготой. Мөн төслийн түншлэгч өрхүүд болон нийт иргэдийн төрөл бүрийн эрүүл хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн хоолны сургалтууд, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг хэрэгжүүлэхээс гадна эрүүл ахуйн зохистой дадал хэвшлийг сайжруулах замаар хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилготой.

“Энэ хүлэмж манай гэр бүлд маш их таалагдсан. Одоог хүртэл ургац авч байгаадаа машихбаяртайбайна.Өөрсдөө идээд, даршлаад, илүү гарсан өргөст хэмх, улаан лооль, чинжүү, газрын алим зэргийг тус бүрийн 1 килограммыг 6,000 төгрөгөөр борлуулж байна. Төслийн хамт олонд ийм гоё хүлэмжтэй болгож өгсөнд баярлаж талархсанаа илэрхийлье” - *А.Алтынгүл, Өлгий сумын тариаланч*

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

Төслийн нээлтийн арга хэмжээг 2024 оны 8-р сарын 22-ны өдөр Өлгий хотод гол түншлэгч талууд болох аймаг, төсөлд хамрагдсан сумдын засаг захиргаа, хамтрагч хүнсний ногооны тариаланчдын төлөөллийн хамт зохион байгуулав. Уг арга хэмжээний үеэр АДРА Монгол болон Баян-Өлгий аймгийн Засаг дарга мөн сумдын Засаг дарга нар төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Төслийн эхний жилд нийт зорилтот 225 өрхөөс эхний 75 өрхтэй хамтран ажиллав. 14 өрхийн тариаланчаас бүрдсэн 5 ногоочдын бүлгийг байгуулав. Манлайлагч 5 сургагч багшийг өмнөх төслийн оролцогчдын дундаас сонгосон ба тус бүр нь 14 өрхийг ахлан ажиллаж байна.

Эдгээр сургагч багш нар нь ил талбайн болон хүлэмжийн ногооны тариалалтад туршлагажсан, бөгөөд төслийн агрономич нь сургагч багш нарыг мэргэжил арга зүйгээр ханган нягт хамтран ажиллав.

Амжилтын түүх

“Намайг Күлиман Жапан гэдэг, 62 настай, тэтгэвэрт гарсан, нөхөр, ач зээ нарынхаа хамт амьдардаг. Би 2000-аад оны эхээр Франц улсаас хэрэгжүүлсэн нэг төсөлд хамрагдан хүнсний ногоо тариалж эхэлсэн бөгөөд эхэндээ цөөн төрлийн хүнсний ногоо л тарьдаг байсан. Харин миний жинхэнэ тариалалтын түүх 2011 онд АДРА-гийн төсөлд хамрагдсанаар эхэлсэн. Төслийн багийн бидэнд зааж өгсөн пермакультур, Митлейдер тарих аргууд надад хамгийн их таалагддаг ба миний олж авсан мэдлэг, туршлага дээр үндэслэн намайг Мастер сургагч багшийн нэгээр сонгосон. Үүнээс гадна биднийг хоол хийх хэд хэдэн сургалтад хамруулж хоол хүнс хадгалах, бэлтгэх янз бүрийн аргыг зааж өгсөн.

Одоо энэ жилээс хэрэгжиж буй шинэ төслийн хүрээнд төслийн багийн гишүүдийн тусламжтайгаар шинээр баригдсан нарны эрчмээр ажилладаг хүлэмжид хүнсний ногоо тариалж сурч байна. 10 сар дуусаж байгаа ч гэсэн би одоог хүртэл ургацаа хураасаар л байгаа бөгөөд ургацдаа маш их сэтгэл хангалуун байна.

АДРА Монгол ОУБ-с хэрэгжүүлж буй Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан төсөл нь ургац хураалт, тариалалтын хугацааг 2-3 сар байсныг 7-8 сар болгон уртасгаж бидний амьдралын хэв маяг, амьжиргааг өөрчлөхөд тусалж байгаа асар их үр дүнтэй төсөл юмаа. Өмнө нь манай аймгийн иргэд зөвхөн төмс, лууван л иддэг байсан бол одоо бид нарны эрчмээр ажилладаг хүлэмжийн ачаар төрөл бүрийн навчит ногоо тариалан идэж байгаа. Мөн энэ жил би “Намрын ногоон өдөр” үзэсгэлэнд өөрийн хийсэн даршилсан ногоогоо танилцуулж бүх бүтээгдэхүүнээ хурдан борлуулж үүнээсээ 2,280,000 төгрөгийн ашиг олсон.

Төслөөс олж авсан туршлага, ур чадвар, найрсаг хамт олон, шинэ найз нөхөд, эцэст нь Баян-Өлгий аймгийн нийгэмд ихээхэн ач холбогдол өгч иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг хангах зорилготой учраас би энэ төслийг бусдад санал болгож хэрэгжүүлээсэй гэж захидаг.”

Төсөл нь нарлаг хүлэмжийн барилгын материалын зардлын 50 хувийг гаргахаар төлөвлөсөн хэдий ч материалын үнэ нэмэгдсэнээр, тариаланчид зардлын 60-аас илүү хувийг өөрсдөө гаргаж хүлэмжээ амжилттай барьж ногоогоо тарилаа. Мөн төсөл нь 8 төрлийн ногооны үр, хүлэмжид ашиглах гар багажийг олгосон юм.

Тариаланчдын тогтвортой ханган нийлүүлэлт, орлогыг нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн зах зээлийн нөхцөл байдал, эрэлт хэрэгцээ, хүнсний ногооны борлуулалтын сувгийн боломжуудыг үнэлэх зорилгоор зах зээлийн судалгаа гүйцэтгэлээ. Судалгаанд үндэслэн 8-р сард дэлгүүр, ресторан зэрэг орон нутгийн худалдан авагчид болон тариаланчдын хооронд шууд нийлүүлэлтийн гэрээ байгуулах ажлыг дэмжин ажиллав. Түүнчлэн тогтвортой нийлүүлэлтийг бий болгоход чиглэсэн маркетинг, борлуулалтын сургалт зохион байгуулж, тариаланчдад нийлүүлэлтийн сүлжээний талаарх ойлголт, загваруудыг танилцуулан, орон нутагт хэрэгжүүлэх арга замыг хэлэлцлээ.

Төслийн хүрээнд хүнсний аюулгүй байдал, шим тэжээллэг хоол хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хамтрагч тариаланчдадаа зориулж хүнсний ногоог даршлах, хатаах, исгэх зэрэг арга техникийн технологийн сургалт зохион байгуулсан.

Ийнхүү газар тариалангийн бүтээмж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадавх, эдийн засгийн бие даасан байдал, чадавхыг нэмэгдүүлснээр орон нутгийн тариаланчдын тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ХАА-н үйлдвэрлэлийг дэмжихийг зорин ажиллаж байна.

БЭЛЧЭЭРИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
АДРА Швейцар, Швейцарын Цурих болон Ааргау аймгууд

Нийт төсөв (ам.доллар)
$348,979.24

Төсөл хэрэгжих хугацаа
2021 оны 6 сарын 1-нээс
2024 оны 5 сарын 31

Зорилтот бүс
Завхан аймгийн Идэр сумын Цэцэрлэг, Мануустай, Загастай, болон Дархан-Уул багийн малчид

Үр шим хүртэгсэд
Орон нутгийн 100 малчин өрх

1 NO POVERTY
2 ZERO HUNGER
13 CLIMATE ACTION
15 LIFE ON LAND

Төслийн танилцуулга

Завхан аймгийн Идэр сумын Цэцэрлэг, Мануустай, Загастай, болон Дархан-Уул багуудын малчидтай хамтран бэлчээрийн цогц менежментийн аргачлалаар бэлчээрийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг сайжруулах зорилготойгоор тус төслийг хэрэгжүүлэв.

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

Сургалт: Сэйвори Институтийн сургагч багш Саймон Гудолл 2024 оны 4-р сарын 23-25-ны өдрүүдэд Завхан аймгийн Идэр сумын 3 багийн малчдад Бэлчээрийн цогц менежментийн 3 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулаа. Энэхүү сургалтаар орон нутгийн малчид бэлчээрийн ургамал нөхөн сэргэх хугацааг тодорхойлон, бэлчээрийн цогц менежментийн аргачлалаар ургамал ургах улиралд буюу зуны бэлчээрээ хэрхэн зөв зохистой ашиглах талаар харилцан ярилцаж, мэдлэг мэдээллээ дээшлүүллээ. Энэ аргачлалыг хамтран хэрэгжүүлэх талаар удахгүй болох Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэн, нэгдсэн ойлголтод хүрч, шийдвэр гаргахаар тохиролцлоо. Сургалтад нийт 41 (22эр; 19эм) малчин болон АДРА-ийн төслийн ажилтнууд хамрагдав.

Төслийн хаалтын үйл ажиллагаа: “Бэлчээрийн цогц менежмент” төсөл нь АНУ-д төвтэй Сэйвори Институтэй хамтран ажиллаж, бэлчээрийн цогц менежментийн аргачлалыг Идэр суманд анх удаагаа туршилтын журмаар нэвтрүүлэн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Ийнхүү төслийн “Үр дүн, сургамж” хаалтын үйл ажиллагааг 2024 оны 4-р сарын 26-ны өдөр Завхан аймгийн Идэр суманд амжилттай зохион байгууллаа.

Энэхүү хаалтын арга хэмжээнд АДРА Монгол олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч Виндэл Маранан, Сэйвори Институтийн сургагч багш, Идэр сумын удирдлагууд, төслийн хамтрагч малчин өрхүүд, сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа малчдын хоршоодын төлөөлөл, орон нутгийн иргэд нийт 75 хүн оролцсон.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, ололт амжилт, сургамжийн талаар санал солилцож, малчид өөрсдийн сэтгэгдлээ хуваалцаж, цаашид ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудыг нэгтгэн товч дүгнэлт, зөвлөмж гаргалаа.

Малчдын хоршоог дэмжив: “Бэлчээрийн цогц менежмент” төслийн хүрээнд малчдын тэр дундаа малчин эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр Завхан аймгийн Идэр сумын Дархан-Уул багийн “Идэр сүүн цацал” малчдын хоршооны сүүний цехийн үйл ажиллагааг тоног төхөөрөмжөөр дэмжив. Төслийн хаалтын ажиллагааны үеэр уг цехийн тоног төхөөрөмжийг гардуулан өглөө. “Идэр сүүн цацал” хоршооны цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Амжилтын Түүх

Жаргалтай саальчин эмэгтэй

Цэрэнхандын Жанцан гэр бүлийн хамт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран Завхан аймгийн Идэр сумын Цэцэрлэг багт амьдардаг. Нутгийнхаа сарлаг саальчдын гол төлөөлөгчдийн нэг болох тэр бээр АДРА Монгол ОУ байгууллагаас хэрэгжүүлж буй Бэлчээрийн цогц менежмент төслөөс зохион байгуулсан төрөл бүрийн сургалт, төлөвлөгөө боловсруулах уулзалтуудад идэвхтэй оролцож өөрийн мэдлэг, ур чадвар, ялангуяа бэлчээрийн төлөвлөгөө боловсруулах аргад сайн суралцсан билээ.

Ийнхүү гэр бүлийн болон хүүхдээ асрах хэрэгцээг тэнцвэржүүлэхээр зоригтой алхам хийж, бүх хонь ямаагаа зарж, сарлаг маллахаар шийджээ. Олон тооны бог малтай харьцуулахад сарлагыг маллахад хялбар байдаг нь түүний гэр бүлд илүү тохиромжтой сонголт болжээ.

Цэрэнханд "Идэр сүүний санаачилга" төслөөр дамжуулан "Сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуй ба шилдэг туршлага" сэдэвт сургалтууддаа оролцсоноороо сүүний үйлдвэрлэлээ ихээхэн нэмэгдүүлсэн. Өдгөө тэрээр найман нэр төрлийн цагаан идээ тогтмол үйлдвэрлэж, өрхийн орлогоо эрс нэмэгдүүлсэн юм. Түүгээр ч зогсохгүй, Сэйвори Институтийн бэлчээрийн цогц менежментийн аргачлалд суралцсанаар бэлчээрийн ургамал нөхөн сэргээх, эрсдэлээс сэргийлэхэд бэлчээрийн талбайг төлөвлөгөөтэй ашиглах нь нэн чухал болохыг олж мэдсэн.

Тэрээр одоо өвөл, зун бэлчээрээ ээлжлэн ашиглаж, бэлчээрийн талбайгаа хамгаалах болон сэргээх аргуудыг амжилттай хэрэгжүүлж байна. Мөн саахалт айлынхаа малчидтайгаа хамтран зуны бэлчээрийн төлөвлөгөө боловсруулж, хамтдаа бэлчээрээ сэлгэж, өөрсдийн амьжиргааг тогтвортой байлгах зорилгоор ажиллаж байна.

ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ - 2 ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам болон АДРА Герман

Нийт төсөв (ам.доллар)
$1,852,830.60

Төсөл хэрэгжих хугацаа
2023 оны 10 сарын 1-нээс
2026 оны 12 сарын 31

Зорилтот бүс
Сэлэнгэ аймгийн 14 сум, Дархан-Уул аймгийн 2 сум

Үр шим хүртэгсэд
41 хоршоо (Сэлэнгэ аймгийн 31, Дархан-Уул аймгийн 10)

Төслийн танилцуулга

“Органик хөдөө аж ахуйн түншлэл 2” төсөл нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам болон АДРА Германы санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн 14 сум, Дархан-Уул аймгийн 2, нийт 16 сумын 41 хоршоотой хамтран хэрэгжүүлж байна.

Тус төсөл нь органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад тэлж, хамтын баталгаажуулалтын тогтолцоо болон органик үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын үр ашигтай сүлжээг талуудын оролцоотойгоор бий болгох замаар органик үйлдвэрлэл эрхлэгчдийн амьжиргааг сайжруулах зорилготой юм.

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

1. Органик ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэлэх зорилтын хүрээнд:

Органик хөдөө аж ахуйн сэдвээр суурь мэдлэг олгох, өвчин, хортон, хог ургамалтай хэрхэн тэмцэх, ургамал хамгаалал болон талбайн зөвлөгөө өгөх сургалт, органик газар тариалангийн сургагч багш бэлтгэх, органик тариалангийн дадлага, хамтын баталгаажуулалт зэрэг 8 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээг давхардсан тоогоор 716 гишүүнийг хамруулан зохион байгуулсан. Мөн хоршооны менежментийн сургалт, зөвлөгөөг хамтран ажилладаг 40 хоршооны удирдлагуудад 2 удаа зохион байгуулав.

Түүнчлэн органик үйлдвэрлэлийг дэмжиж органикийн стандарт шаардлагыг хангасан үр, бордоо, хөдөлмөр хөнгөвчилсөн багаж, жижиг тоног төхөөрөмж, хүлэмжийн дэмжлэгийг 22 хоршоо, 2 сургууль, 2 цэцэрлэгт үзүүллээ.

9 сумын 21 хоршооны 91 гишүүн шинээр органик үйлдвэрлэлд шилжиж, 5 хамтын баталгаажуулалтын байгууллагыг хамтран байгуулж, органик үйлдвэрлэлд шилжихээ илэрхийлж, тангараг өргөв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд давхардсан тоогоор нийт 376 бүтээгдэхүүнийг бүртгүүлж, албан ёсны мэдэгдэл, органик лого хэрэглэх эрх авсны 117 нь шилжилтийн үеийн, 193 хүнс нь 100% Органик Монгол хүнс байна.

Ийнхүү 2024 онд нийт 75 га-д 32 нэр төрлийн төмс, хүнсний ногоо тариалан 886.1 тонн ургац, 9 тонн органик зөгийн балыг хураан авч зах зээлд нийлүүлж байна.

2. Орон нутгаас нийлүүлдэг органик бүтээгдэхүүний нийлүүлэлт, худалдааны сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

Хоршооны бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүй, маркетинг, борлуулалт, хүнсний ногоо даршлах нөөшлөх, нэмүү өртөг шингээх технологийн болон мэргэжлийн сургалтыг 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 244 гишүүнийг хамруулсан. Газар тариалангийн бус улиралд эрхлэх бизнесийн үйл ажиллагааг тэлэх зорилгоор нийт 32 хоршоонд оёдол, эсгий, мужаан, сүү, мах, даршилсан нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бага оврын тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Мөн органик бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, хэрэглэгчдэд сурталчлах зорилгоор 5 удаагийн үзэсгэлэн худалдаанд Сэлэнгэ органик, Дархан органик баталгаажсан бүтээгдэхүүнээр оролцлоо. Дархан, Сэлэнгийн органик үйлдвэрлэгчид органик хүнсний ногоо, зөгийн бал, бусад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоогоор дамжуулан үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд шууд хүргэх зорилгоор Улаанбаатар хотод органик бүтээгдэхүүний дэлгүүр ажиллуулахаас гадна 4 газартай төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийн гэрээ байгуулах ажлыг дэмжин ажиллалаа.

3. Органик үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, цаашдын зорилтыг тодорхойлох, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаас нийлүүлдэг органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, оролцогч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээний нийт 18 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулан давхардсан тоогоор 926 гишүүнийг хамруулан бодлого боловсруулагчдад органик үйлдвэрлэл эрхлэгчдийн дуу хоолойг хүргэн ажиллаж байна.

Гамшгийн хариу арга хэмжээ

ЗУДЫН ГАМШИГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
АДРА Интернэйшнэл, АДРА Ази, АДРА Герман, АДРА Канад болон Монголын 7 дах өдрийн Адвентист сүм

Нийт төсөв (ам.доллар)
$40,000.00

Төсөл хэрэгжих хугацаа
2024 оны 1 сарын 10-наас
2024 оны 5 сарын 9

Зорилтот бүс
Сүхбаатар аймгийн
Сүхбаатар сум

Үр шим хүртэгсэд
768 малчид,
3,197 шууд бус үр шим хүртэгчид

Гол сорилтууд & яаралтай хэрэгцээ

- Өвс, тэжээлийн хомсдол болон үнэ намраас хойш тав дахин нэмэгдсэн.
- Сүүлийн олон арван жил тохиогоогүй зудын улмаас олон аймгийн, сумд, малчин өрхүүд хүндээр нэрвэгдэж, нийт тусламж нэн шаардлагатай өрхүүдэд тусламж үзүүлэх боломжгүй байдалд хүрсэн.
- Үргэлжилсэн малын хорогдол нь малчдын амьжиргааг сүйрүүлж болзошгүй ноцтой аюул дагуулж байв.

Төслийн танилцуулга

Тус байгууллага нь Засгийн газар, НҮБ болон бусад олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд зудын яаралтай хариу арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлсэн.

Бидний яаралтай тусламж

ГАМШИГ	ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	ТУСЛАМЖ
2023 оны 11 сар	2024 оны 1 сар	2024 оны 5 сар
11-р сарын эхээр цас их орж, 12-р сард агаарын температур -40 градусаас доош унасан	ХХААХҮЯ, ОБЕГ зэрэг засгийн газрын байгууллагуудтай нягт хамтран ажилласнаар малчин өрхүүдэд мөнгөн тусламж үзүүлж, малын сэг зэм цэвэрлэхэд түлшний зардлаар дэмжсэн	Цаг тухайд нь дэмжлэг үзүүлснээр малчид өөрсдөөө болон малдаа нэн шаардлагатай зүйлсийг худалдан авах боломжтой болсон

Г.Ганхуяг, Сүхбаатар сумын малчин

Онцгой байдлын ерөнхий газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зудын нөхцөл байдлын талаар 2024 оны 1-р сарын 15-нд шинэчлэгдсэн мэдээллийг хүлээн авсны дараа тус байгууллага нь үндэсний хэмжээнд албан ёсны онцгой байдал зарлахаас өмнө АДРА Азийн бүс болон АДРА Интернэйшнэлд гамшгийн хариу арга хэмжээ үзүүлэх ажиллагааг идэвхжүүлэх хүсэлтийг илгээсэн.

“Би гамшигт зудын уршгаар 600 гаруй толгой малаа алдсан. Их хэмжээний бороо орсны дараагаар эрс хүйтэрч нойтон цас орсноор газрын хөрс мөсөөр хучигдаж өвсийг далдалсан байлаа. Туйлын ширүүн эрс тэс цаг агаарын үзэгдэл нь өвс, тэжээлийн хомсдолд хүргэж, малыг минь туйлдуулж, осгож эндэхэд хүргэсэн”
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын малчин Г.Ганхуяг

Эхний 67 тусламж нэн шаардлагатай өрхөд бэлэн мөнгөний шилжүүлгийг шуурхай гүйцэтгэв. Эхний удаагийн зудын хариу арга хэмжээг дэмжих ажиллагааг гүйцэтгэсний дараагаар нөхцөл байдал улам хүндэрч байгаатай холбогдуулан дараагийн өргөтгөсөн хариу арга хэмжээний хүрээнд АДРА-гийн сүлжээ байгууллагуудын дэмжлэгтэйгээр нэмэлтээр 100 өрхөд тусламж үзүүлэхээр хариу арга хэмжээний төслийг боловсруулав.

Баталгаажуулалт ба бэлэн мөнгө шилжүүлэлт

Бүх мэдээллийг (нэр, банкны мэдээлэл) малчидтай утсаар залган шалгаж, 2024 оны 2-р сарын 8-нд сонгосон айлуудын дансанд 660,000 төгрөг шилжүүлсэн. Бэлэн мөнгө шилжүүлгийн үр нөлөөг үнэлэх зорилгоор 2024 оны 2-р сарын 19-21-ний өдрүүдэд шилжүүлгийн дараах мониторингийн аялалд нийт хамрагдсан хүмүүсийн 10 хувийг түүврийн аргаар сонгож хяналт хийсэн.

Санхүүгийн тусламжаас гадна орон нутгийн засаг захиргаанаас малчдад туслах, сэг зэм цэвэрлэхэд нөөц бололцоогоо шавхсан Сүхбаатар суманд шатахууны дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг төслийн 2-р шатанд тусгаж өгсөн. Сумын ЗДТГазраас халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд үхсэн малыг хогийн цэгт булах, халдваргүйжүүлэхэд зориулж түлшний тусламж үзүүлэхийг АДРА Монгол ОУБ-с хүссэн.

Дараагийн өргөтгөсөн хариу арга хэмжээний хүрээнд нэмэлтээр 100 өрхийг сонгож 4 сарын сүүлийн долоо хоногт бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлсэн.

Малчид болон орон нутгийн удирдлагууд тус гамшгийн хариу арга хэмжээний төсөлд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, АДРА Монгол-с хэрэгжүүлсэн цагаа олсон тусламж үр дүнтэй байсныг үнэлж талархал илэрхийлэв.

Мал үржүүлгийн хөгжил

НАРИЙН БОЛОН НАРИЙВТАР НООСТ ХОНИНЫ ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ - 2

Санхүүжүүлэгч
АДРА Интернэйшнэл, АДРА Ази, АДРА Австрали, АДРА Япон, АДРА ХонгКонг, Монгол дахь Австралийн Элчин Сайдын Яам

Нийт төсөв (ам.доллар)
$185,000 (Туршилтын төсөл)
$43,000 (Төслийн 2-р үе)

Төсөл хэрэгжих хугацаа
2022 оны 7 сарын 1-нээс
2024 оны 6 сарын 30
2024 оны 7 сарын 1-нээс
2025 оны 6 сарын 30 (2-р үе)

Зорилтот бүс
Сэлэнгэ ба Дархан-Уул аймгууд

Үр шим хүртэгсэд
80 малчин өрх, 9 малын эмч
23 малчин өрх (2-р үе)

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

2023 оны 10-р сарын 17-ноос 20-ны хооронд Австралийн мэргэжилтнүүд, Малын удмын сан, орон нутгийн малын эмч нартай хамтран зохиомол хээлтүүлгийг нийт 305 хонинд хийснээс 165-д хөлдөөсөн үрээр, 140-д хөврөлийн аргаар хийв. Хээлтүүлгийн хувь дунджаар 65% буюу нийт хонины 198 орчим нь хээлтсэн байна. 2024 оны 5 сарын байдлаар 90 хурга эрүүл саруул бойжиж, цаашид үржлийн ажилд ашиглагдах суурь тавигдаж, хонь үржүүлгийн ажлын чанар сайжирч, үүлдэр угсаа, генетикийн онцлог, ач холбогдлыг харуулж байгаа нь төслийн бяцхан амжилт болж байна.

Төслийн танилцуулга

Монгол Улс 1990-ээд оны үед 3-4 төрлийн нарийн ноост үүлдрийн таван зуу гаруй мянган тоо толгой хоньтой, нарийн ноосны дотоодын хэрэгцээг 100 хувь хангаж байсан боловч сүүлийн 30 жилийн хугацаанд үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн системтэй арга хэмжээ аваагүйн улмаас нарийн ноост хонины тоо толгой ердөө арван гурван мянга орчим болж буурсан. Төслийн 1-р үе шатанд Монголын нарийн, нарийвтар ноост хонины чанарыг сайжруулах зорилгоор Австралийн меринос үүлдрийн гүн хөлдөөсөн үр болон хөврөлийг импортлон оруулж, дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх, хөврөл шилжүүлэн суулгах сургалтуудыг зохион байгуулж зохиомол хээлтүүлэг, хөврөлийн ажлыг эхлүүлсэн. Төслийн 2-р үе шатанд үржлийн ажлыг үргэлжлүүлэн, мөн нарийн нарийвтар ноост хонь үржүүлэгчид, малчдад түлхүү анхаарч ажиллалаа. Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран малчдад ойр орон нутагт дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулсан, мөн малчид болон мэргэжилтнүүдэд чадамж дээшлүүлэх зорилготой практик сургалтуудыг зохион байгуулсан нь энэхүү төслийн онцлог байв.

Зохиомол хээлтүүлгээр төрсөн хургануд

Шейр Монгол ТББ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Орхон сумын малчдад Хангай болон Орхон үүлдрийн нарийн ноост хонь хяргах сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалт нь малчдад ноосыг тусгай хяргах машин ашиглаж хяргах чадавхыг олгох, тоног төхөөрөмжийг үр дүнтэй аюулгүй ашиглах, нэг хониноос хяргаж авах ноосны гарцыг нэмэгдүүлэх зорилготой байлаа.

АДРА-гийн төслийн баг, АДРА Азийн зөвлөх, Малын удмын сан, Сэлэнгэ аймгийн болон сумын удирдлагууд, албаны хүмүүсийн хамт гуравдугаар сарын дундуур төллөсөн хурганы нөхцөл байдал, мөн дараагийн шатны төслийн хүрээ, намрын хамтран хэрэгжүүлэх дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх үйл ажиллагааны талаар санал солилцов.

Мөн тухайн баг гуравдугаар сарын дундуур төллөсөн хурганы нөхцөл байдал, түүнчлэн Орхон суманд болсон хонь хяргах сургалтын үеэр гарсан ноосоор хийгдсэн бүтээгдэхүүнд үнэлгээ дүгнэлт өгч ажиллаа.

Нарийн ноост хонь үржүүлэгчдийн судалгаа, төсөлтэй хамтран ажиллагч малчин өрхүүд

Төслийн баг 10 сард Сэлэнгэ аймгийн Орхон, Сайхан, Цагааннуур сумдын нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэгч малчидтай уулзаж, нийт 3 сумын 23 малчин өрх сайн дурын үндсэн дээр зохиомол хээлтүүлэгт хээлтэгч малаа хамруулах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

Мөн Австралийн Элчин сайдын яамнаас санхүүжиж буй энэхүү төслийн 2-р шатанд Элчин сайдын яамны дэд тэргүүн Эндрью Бэрримэн тэргүүтэй төслийн баг 2024 оны 11 сарын 1-нд мониторингийн айлчлал хийлээ.

Тохиромжтой хэвшлийн эм хонийг үржилд шилэн сонгох, ээмэгжүүлэх

Малчдаас авсан судалгаа, хамтын ажиллагааны гэрээнд үндэслэн төсөл нь Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, нарийн нарийвтар ноост хонь үржүүлгийн мэргэжилтнээс бүрдсэн ажлын багаар 3 сумдын малчин өрхүүдийн үржилд тохирох хээлтэгч эм хонийг биеийн ерөнхий нөхцөл, үүлдрийн хэв шинж хадгалсан байдал зэргийг үнэлэн сонгож, биеийн жинг үзэж тэмдэглэл хөтөллөө.

Зохиомол хээлтүүлэг

Сэлэнгэ аймгийн 3 сумын 23 малчин өрхийн 630 эм хонинд дурангийн аргаар зохиомол хээлтүүлгийг орон нутагт нь, Малын удмын сан, тухайн сумын засаг захиргаатай хамтран хийж гүйцэтгэлээ. Түүнчлэн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь Австралийн Baderloo, Dohne merino үүлдрүүдийн гүн хөлдөөсөн үрээр Дархан-Уул аймгийн Хонгор сум дахь үржлийн сүргийн 50 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн. Бид нарийн ноост Хангай үүлдрийн хонинд Centre Plus болон Karbullah нэн нарийн ноост үүлдрийн үр, Орхон үүлдрийн хонинд Dohne merino болон Baderloo үүлдрийн үрийг тус тус ашиглав.

Мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх

Малын удмын сангийн үндэсний төвийн баг дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх өндөр ур чадварыг эзэмшсэнээ бататган 630 эм хонинд бие даан орон нутагт үр шилжүүлэн суулгасан нь төслийн хамтын ажиллагааны бодит үр бүн байлаа. Түүнчлэн Мал Аж Ахуй Биотехнологийн Их Сургуулийн 9 оюутан дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх аргатай танилцан мэдлэг, ур чадвараа практик дээр бэхжүүлэв..

Сум орон нутагт зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулсан нь төсөлтэй хамтран ажиллаж буй малчид өөрсдийн биеэр пункт дээрх үржлийн ажилбарыг харах боломжтой байлаа. Хээлтүүлсэн эм хонь нэг бүрийг ээмэглэн, дугаарын дагуу бүртгэлжүүлсэн нь цаашдын үржлийн бүртгэл, төлөрхөг байдал, ур төлөөр нь шалгаруулах зэрэг тоо баримтад тулгуурлан системтэй үржлийн ажлыг хэрэгжүүлэх боломжийг хангах юм.

Эрүүл мэнд/Шим тэжээл

ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулган, АДРА Интернэйшнэл, АДРА Хонг Конг, АДРА Австри

Нийт төсөв (ам.доллар)
$510,000.00

Төсөл хэрэгжих хугацаа
2023 оны 6-р сарын 01-нээс
2026 оны 5-р сарын 31

Зорилтот бүс
Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргүүд

Үр шим хүртэгсэд
2000 өсвөр үеийнхэн

Төслийн танилцуулга

Энэхүү төсөл нь АДРА Интернэйшнэл ОУБ-ын халдварт бус өвчний (ХБӨ) эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэхэд чиглэсэн цогц аргачлалыг манай улсын онцлогтой уялдуулан хэрэгжүүлэх зорилготой туршилтын төсөл юм. CELEBRATIONS буюу эрүүл амьдралын 12 зарчмыг илэрхийлсэн товчлолоос манай улсын өсвөр үеийнхний дунд илүү хэрэгцээтэй байгаа нь тогтоогдсон зөв сонголт, дасгал хөдөлгөөн, зориг тэвчээр, өөдрөг үзэл, хоол тэжээл, гэсэн эрүүл амьдралын зарчмын хүрээнд бид үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Бидний эрхэм зорилго бол 12-15 насны Монголын өсвөр үеийнхэнд эрүүл аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлснээр ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

Боловсролын ерөнхий газартай хамтран ажиллаж Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль, Сонгино хайрхан дүүргийн Хөгжил цогцолбор сургууль, Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургууль, Чингэлтэй дүүргийн Тусгал хувийн сургуулийг шалгуурын дагуу төсөл хамтран хэрэгжүүлэх сургуулиар сонгов.

Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооноос судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг албан ёсоор авснаар “Улаанбаатар хотын 12-15 настай өсвөр үеийнхэнд эрүүл зан үйлд суралцахад ээлтэй орчин бүрдүүлэх нь” судалгааг АДРА Монгол, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, АНУ-ын Лома Линдагийн их сургууль хамтран зохион байгуулав. Энэхүү эрүүл амьдралын мэдлэг, хандлага, дадлын талаарх суурь судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө Лома Линдагийн их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн судлаач Жиа Хернандаз “Хүний орлолцоотой судалгаанд баримтлах ёс зүй ба санал гомдлыг шийдвэрлэх арга зүй” сургалтыг 2024 оны 2-р сарын 19-22ны хооронд Нийгмийн эрүүл мэндийн төвийн ба Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн судлаачдын багийн 30 гишүүдэд зохион байгуулж сертификат олголоо.

Өсвөр үеийнхний саналыг тусган хоёр сургуулийн эрүүл мэндийн өрөөг засварлах ажлыг гүйцэтгэв. Ингэхдээ бид хүүхдүүдийн саналд тулгуурлан эрүүл мэндийн өрөөг тав тухтай, тайван амгалан мэдрэмж төрүүлэх орчныг бий болгохыг зорьсон.

12-15 насны хүүхдүүдийн өөрсдийнх нь сайн дурын хүсэлтэд үндэслэн эрүүл мэндийн клубуудыг сургуулиудад байгуулав. Тусгал сургуульд нэг, Эрдмийн Оргил сургуульд хоёр эрүүл мэндийн клуб нээж нийт 93 хүүхдийг хамруулсан. Эдгээр хүүхдүүдэд зориулан зуршлын хөтөч бүхий тэмдэглэлийн дэвтрийг хэвлүүлсэн.

Хавтасны зургийг "Эрдмийн Оргил" цогцолбор сургуулийн 4-2 ангийн сурагч Л.Оюумаа

Суурь судалгаанаас гадна Саад бэрхшээлийн судалгаа, хүн төвтэй аргачлалын дагуу өсвөр насны хүүхдүүд, эцэг эх, болон багш нарын дунд нийт 7 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан үр дүн, санал санаачилгад үндэслэн эрүүл амьдралын мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтрагч талуудын хамт боловсруулан, хэрэгжүүлж байна.

Эрүүл амьдралын 12 зарчмаас дасгал хөдөлгөөн, тэсвэр тэвчээр, өөдрөг үзэл, болон хоол тэжээл гэсэн дөрвөн зарчмын хүрээнд үйл ажиллагаагаа туршиж, хэрэгжүүлж эхлээд байна. 5-р сарын 8-ны өдөр “Эрдмийн оргил” сургуулийн дотуур байранд “Эрүүл хооллолт” үйл ажиллагааг зохион байгуулж, Монголын Адвентист чуулганы сургагч багш Ж.Пүрэвдулам дотуур байрны өсвөр үеийнхэнд цагаан хоол бэлтгэх талаар сургалт явууллаа. Эрүүл хооллолт нь эрүүл амьдралын хэв маягийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бидний зорилго бол хүүхдүүдийн зөв хооллолт, өдөр тутмын хоолны дэглэмийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх юм.

Дасгал хөдөлгөөнийг хэвшил болгох хүрээнд Налайх дүүргийн Эрдмийн-Оргил цогцолбор сургууль дээр 26 хүүхдийг хамруулсан явган алхалтын клубийг байгуулсан. 2024 оны 06 сарын 19-ний өдөр Тэрэлжид нэг өдрийн аялал зохион байгуулж, хүүхдүүд хамтдаа цагийг хөгжилтэй үр дүнтэй өнгөрөөсөн. Энэхүү клубийн үйл ажиллагааны үеэр бид олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн хичээлийн жилийн нээлттэй уялдуулан, төслийн нээлтийн үйл ажиллагааг Налайх дүүргийн “Эрдмийн-Оргил” цогцолбор сургууль дээр зохион байгуулж, Налайх дүүргийн Засаг дарга Х.Анхбаяр, АДРА Монгол ОУБ-ын суурин төлөөлөгч Винделл М.Маранан, Налайх дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Б.Энх-Учрал, Эрдмийн-Оргил цогцолбор сургуулийн захирал О.Оюунтуяа, Тусгал сургуулийн захирал Ц. Өлзийжаргал болон Адвентист Чуулганы төлөөлөгчид, мөн 700 гаруй сурагчид арга хэмжээнд оролцов.

Нөлөөлөл

ДЭМ ДЭМЭНДЭЭ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч
АДРА Монгол ОУБ-ын хамт олон, хувь хандивлагчид, Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулганы Дэлхийн сүмийн Ерөнхийлөгч

Нийт төсөв (ам.доллар)
$4,347

Төсөл хэрэгжих хугацаа
Жил бүр нэг удаа (2024 оны арваннэгдүгээр сарын 19)

Зорилтот бүс
Сонгинохайрхан дүүргийн 41-р хороо

Үр шим хүртэгсэд
Зорилтот бүлгийн 460 иргэн болон 50 хүүхэд

1 NO POVERTY

2 ZERO HUNGER

3 GOOD HEALTH AND WELL-BEING

Төслийн танилцуулга

Тусбайгууллагаасжилбүрзохионбайгуулдаг Дэм дэмэндээ төсөл нь Улаанбаатар хотын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхүүдэд хүнсний тусламжийн багц болон 6-16 насны хүүхдүүдэд өвлийн дулаан гутал олгодог. Энэхүү төслийг нийгэм дэх дэмжлэг шаардлагатай иргэдэд туслах, хүрч ажиллахын тулд санаачилсан юм. 2021 оноос эхэлсэн энэ төсөл нь нэгэнтээ Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүдийн зарим хороодод хэрэгжсэн.

2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд

2024 онд төслийн баг Сонгинохайрхан дүүргийн 41-р хорооны Засаг дарга болон хорооны ажилчидтай хамтран Улаанчулуутын хогийн цэг дагуух өрхүүдэд 10кг гурил, 5кг будаа, 2 литрийн ургамлын тос, 2кг сахар, 4ш уут нарийн гоймон болон 2ш талх агуулсан хүнсний тусламжийн багцыг мөн тусламж нэн шаардлагатай 50 хүүхдэд өвлийн дулаан гутлыг тараав.

Энэ төслийг тус байгууллагын ажилчид өөрсдийн цалин, гэр бүлийн хандив, сайхан сэтгэлт иргэд болон Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулганы Дэлхийн сүмийн Ерөнхийлөгчийн тусламжтайгаар санхүүжүүлдэг.

Санхүүгийн тайлан

Салбар / Төслүүд	Нийт төсөв (ам.доллар)	Зардал (төгрөг)	Зардал (ам.доллар)
Удирдлага	$123,819.84	432,604,110.11	$125,428.85
Органик хөдөө аж ахуйн түншлэл-2 төсөл	$1,852,830.60	2,471,898,743.56	$695,016.73
Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх төсөл	$510,000.00	643,509,065.95	$186,531.96
Бэлчээрийн цогц менежмент төсөл	$348,979.24	61,968,297.00	$18,328.12
Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан төсөл	$340,000.00	436,075,673.00	$97,209.04
Нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах төсөл	$185,000.00	32,786,317.21	$9,697.08
Нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах төсөл-2	$43,000.00	88,226,308.00	$25,797.17
Зудын яаралтай хариу арга хэмжээний төсөл	$40,000.00	135,680,000.00	$40,000.00
Дэм дэмэндээ төсөл	$4,347.00	14,391,230.00	$4,270.39
НИЙТ	**$3,447,976.68**	**4,317,139,744.83**	**$1,262,229.29**

2024/12/30-ны Монголбанкны ханшаар

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АГУУЛГА

НИЙТ ЗАРДАЛ



Санхүүжүүлэгч болон хамтрагч байгууллагууд

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Australian Embassy
Mongolia

SWISSLOS
Kanton Aargau

Kanton Zürich
Lotteriefonds

GOVERNMENT OF MONGOLIA
MINISTRY OF FOOD, AGRICULTURE AND LIGHT INDUSTRY

GOVERNMENT OF MONGOLIA
MINISTRY OF HEALTH

Governor's Office of Selenge Province

Governor's Office of Darkhan-Uul Province

Governor's Office of Bayan-Ulgii Province

Seventh-day Adventist Church
MONGOLIA MISSION

Savory

Help International

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
NATIONAL CENTER FOR PUBLIC HEALTH

LOMA LINDA UNIVERSITY
School of Public Health

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Governor's Office of Zavkhan Province

Governor's Office of Ider Soum

National Federation of Mongolian Consumers Associations (NFMCA)

National Association of Mongolian Agricultural Cooperatives (NAMAC)

Institute for Plant and Agricultural Sciences (IPAS)

ADRA International

ADRA Asia Regional Office

ADRA Germany

ADRA Canada

ADRA Switzerland

ADRA HongKong Ltd

ADRA Japan

ADRA Australia

ADRA Austria

ХААИС
MONGOLIAN UNIVERSITY OF LIFE SCIENCES

СЭТГЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
1929

Seventh-day Adventist Church
General Conference of Seventh-day Adventists